

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2020 ОНЫ 06 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:** Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал тайлант сард 1 удаа хуралдаж, Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тухай тус тус хэлэлцэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 22 өргөдөл бичгээр хүлээн авч, 14 өргөдлийг шийдвэрлэж, 8 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 4 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, шийдвэрлэлт 64.4 хувьтай байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл бүртгэгдээгүй, Засгийн газрын 1111 төвд тайлант сард санал хүсэлт ирээгүй болно.

**Аймгийн Онцгой комиссын ажлын талаар:** Аймгийн Онцгой комисс 2020 оны 6 дугаар сард 1 удаа хуралдаж Ховд аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 11 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 3 тогтоол, Онцгой комиссын даргын 2 тушаал, үүрэг чиглэл хүргүүлэх тухай холбогдох албан бичгийг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 2/1489 дугаартай албан үүрэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн сонгуулийн 91 хэсгийн хороонд үүрэг гүйцэтгэх Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, орон нутгаас ажиллах алба хаагчдыг 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр томилгоожуулж аймгийн Онцгой комиссын даргын тушаал гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх журам"-ын дагуу санал авах байранд халуун хэмжигч, гар ариутгагч, амны хаалт, бээлий зэрэг хамгаалах хэрэгслийг сонгуулийн хэсгийн хорооны ажилтан, сонсогчийн тоогоор байршуулж, халдвар хамгааллын дэглэм сахиулан, аймгийн санал авах 91 хэсгийн хороонд 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 06.00 - 21.00

цагийн хооронд Онцгой байдлын газраас 41, Эрүүл мэндийн байгууллагаас 97, төрийн байгууллагаас 148, нийт 286 алба хаагч үүрэг гүйцэтгэлээ.

“МоЭнКо” ХХК-ын Хөшөөтийн уурхайн нүүрс, “Эй Эл Жи Ти” ХХК-ын хүдэр тээврийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Булган боомтоор тээвэрлэгдэж байгаа нүүрс болон хүдэрийг Улсын Онцгой комиссоос томилогдсон ажлын хэсгийн зөвлөмж, “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын дагуу Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газраас нийт 6 албан хаагч 3 техник хэрэгсэлтэйгээр хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяныг 1 сарын хугацаанд өрнүүлэх удирдамжийн дагуу орон нутгийн хэмжээнд “COVID-19” халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хүн ам олноор цуглардаг худалдаа, үйлчилгээний газруудаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Жаргалант сум хамтран ажиллах хувиар гаргаж 7 хоног бүр ард иргэдийг маск зүүж хэвшүүлэх, маскгүй иргэдэд үйлчлэхгүй байх талаар иргэд олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг, мэдээллийг орон нутгийн телевиз болон цахим сайтуудаар дамжуулан мэдээлж байна.

**Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын улсын төсвийн санхүүжилт 6 дугаар сард 41231.0 сая төгрөг хийгдэхээс 39282.1 сая төгрөг хийгдэж цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 4279.7 сая төгрөгийн санхүүжилтээс 2330.8 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдын санхүүгийн дэмжлэгт 6803.2 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 4237.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээс сургуульд 18070.2 сая төгрөг, цэцэрлэгт 8145.5 сая төгрөг, хүн эмнэлэгт 3052.3 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 257.7 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 272.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх 6 сургагч багшийг аймгийн хэмжээнд бэлтгэж, төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээллийг цалингийн нэгдсэн системд үнэн зөв шивж нэгтгэх ажлын зохион байгуулалт гүйцэтгэл 91,5 хувьтай байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 6937 ширхэг зардлын ваучер бичиж, 21045,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг зардлын ваучераар гүйцэтгэж ажиллав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээг шинээр нэвтрүүлж, төсвийн захирагч, нягтлан бодогч 300 гаруй алба хаагчдад тайлант сарын мэдээллээ тухай бүр оруулж хариуцлагатай ажиллах талаар мессежээр чиглэл өгч ажиллалаа. 2020 оны 5 дугаар сарын байдлаар шилэн дансны мэдээллээ байршуулсан дундаж үзүүлэлт 88,6 хувьтай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тайлант сард Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийлээ. Мөн аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлын дагуу аймгийн Мал эмнэлэгийн газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тайлан мэдээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүллээ.

Аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны тайлант сарын НӨАТ-ын тайланг 100 хувь хүлээн авч, тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-дыг Тахаст болон Trips программд бүртгэлээ. Үүнд: ХХК 75, Нөхөрлөл 4, төрийн бус байгууллага 9, салбар 1, сан 1, хоршоо 4, нийт 96 аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэсэн.

Төрийн сангийн цахим сайтаар дамжуулан татварын орлогын хуулгыг өдөр бүр нэр, төрөл бүрээр татварын мэдээллийн сангийн боловсруулалт хийж, татварын данс андуурч орсон 24 татвар төлөгчтэй холбоотой 5 төрлийн татварын 28,7 сая төгрөгийн залруулах бичилт хийлээ.

Улс, аймаг, сум орон нутгийн төсөвт нийт 6603,2 сая төгрөг оруулахаас 2020 оны 06 дугаар сарын 28-ны байдлаар 7081,4 сая төгрөг төвлөрсөн нь 107,2 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 1644,0 сая төгрөг оруулахаас 1832,3 сая төгрөг орж 110,1 хувиар, аймгийн төсөвт 3006,4 сая төгрөг оруулахаас 4245,2 сая төгрөг орж 105,9 хувиар, сум орон нутгийн төсөвт 932,8 сая төгрөг оруулахаас 987,3 сая төгрөг орж 105,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Татварын хяналт шалгалтанд 13 татвар төлөгчийг хамруулж, татвар төлөгчийн гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 3703,8 сая төгрөгийн зөрчилд 123,2 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 26,4 сая төгрөгийн торгууль, 3.7 сая төгрөгийн алданги, нийт 153,9 сая нөхөн татвар торгууль, алданги ногдууллаа.

Аймгийн Статистикийн хэлтэс хүн ам орон сууцны тооллогын дэлгэрэнгүй тайлангийн эхний бүлгүүдийн мэдээллийг нэгтгэж ҮСХ-нд хянуулж, хураангуй тайланг аймгийн тооллогын комисст танилцуулахаар бэлтгэж байна. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Тахилт, Баатархайрхан багт, Буянт сумын Норжинхайрхан, Ховд сумын Баянбулаг, Булган сумын Далт, Үенч сумын Нарийнгол багуудад, ажиллах хүчний судалгааг Үенч сумын Жаргалан, Булган сумын Бүрэнхайрхан, Манхан сумын Төгрөг гол, Чандмань сумын Сүлжээ багуудад тус тус хийгдэж байна.

**Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:**

**Шүүхийн шинжилгээний алба:** Тус албанд хандаж 22 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 82 ирүүлснийг хүлээн авч бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 11 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим [khovd\\_nifs@yahoo.gov](mailto:khovd_nifs@yahoo.gov) хаягаар авч ажиллаж байна.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 5 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 48, эд эсийн шинжилгээт 5, хавтаст хэрэг 2, тусгай шинжилгээ 7, криминалистикийн 15 шинжилгээг тус тус хийж, дүгнэлт гаргав. Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 39 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 59 ширхэг мөр, гутлын мөр 17, тээврийн хэрэгслийн мөр 10, биологийн гаралтай ул мөр 1, бичил мөр 2, эвдлэгч багажны мөр 1, бусад ул мөр, 46 эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 60, гарын мөр 16 авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийж ажиллав.

**Цагдаагийн газар:** Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Аюулгүй ажиллагаа-Амьдралын баталгаа”, “Өөрчлөлтийг өөрөөсөө-Өөрөөр амьдаръя” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг ханган ажиллаж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр биечлэн 3 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, баривчлагдсан хүмүүст “Зөрчлийн тухай хууль” “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт, хор уршиг”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” сэдвүүдээр сургалт, мэдээлэл хийж, олон нийтийн газар, гудамж талбай зэргийн хаалга, мэдээллийн самбарт арга хэмжээг сурталчилсан 200 ширхэг зурагт хуудас байршуулж, ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсээс бэлтгэсэн 29 төрлийн видео шторк, постерыг аймгийн хэмжээнд хандалт ихтэй группүүдэд түгээлт хийж, илтгэх хуудсыг хүргүүлж ажиллав.

Дээрх арга хэмжээнүүдийн талаар Тэмүүлэл fm 89.1 радиогоор ярилцлага өгч, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аж ахуй нэгжүүд аймгийн Засаг даргын захирамжийг биелүүлж байгаа эсэх талаар Ховд телевизтэй хамтран шөнийн сурвалжлага 1 удаа бэлтгэн, Ховд телевизээр дамжуулан иргэдэд хүргэлээ.

Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийн дагуу согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр иргэдээс цахим санал асуулга авах ажлыг зохион байгуулж, 2 төрлийн видео, 1 мэдээг бэлтгэн, байгууллагын пэйж хуудсанд байршуулж, олон нийтийг цахим санал асуулгад идэвхтэй оролцуулах чиглэлээр ажиллаж байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтнуудад “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” сэдвээр цахим сургалтыг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын 2020 оны А/150, А/186, А/187 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, согтууруулах ундаа худалдаалах, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй 116 газрын үйл ажиллагаанд

эргүүлийн хяналтаар шалгалт хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зохион байгуулж буй ажил арга хэмжээ, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой 5 сурвалжлага мэдээлэл, 1 нэвтрүүлэг, 2 төрлийн видео бэлтгэн Ховд телевиз, Жаргалант телевизээр дамжуулан иргэдэд хүргэж, Ховд Цагдаагийн газар facebook хаяг, пэйж хуудас цахим сайтад 156 удаагийн давтамжтайгаар цаг үеийн болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, постер, сэрэмжлүүлэг зэргийг байршуулж мэдээлэв.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги:** Тус анги нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр төлөвлөгөөний дагуу 2 удаагийн төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа. Тус ангийн алба хаагчдын 2020 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тооцон журмын дагуу дүгнэж, даргын зөвлөлөөр үнэлгээг хэлэлцүүлэн ажлын явц үр дүнг нийт алба хаагчдад танилцуулж цаашид ажлын сахилга хариуцлагаа сайжруулж, манлайлан ажиллах, ажилдаа хандах хандалагаа өөрчилж ажлын бүтээмжтэй ажиллахыг удирдлагаас үүрэг болголоо.

Шинэ төрлийн короновирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг баримтлан 2019-2020 онд зохион байгуулагдах сургалт үйл ажиллагааг хэвийн явуулахад анхаарч онлайн хэлбэрээр сургалтыг зохион байгуулж, алба хаагчдыг бүрэн хамруулж чадавхжууллаа.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд хоригдол, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс нь 29 иргэнд гадаад паспорт олгож, 167 иргэнд иргэний үнэмлэх шинээр олгож, 229 иргэнд үнэмлэхийн сунгалт хийж, 110 иргэнд үнэмлэх дахин олгож нийт иргэний бүртгэлийн чиглэлээр 1506 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлээр нийт 310 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Үүнээс: Төрөлт 214, Үрчлэлт 2, Овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл-8, Эцэг тогтоолт 3, Гэрлэлт 39, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1, Нас барсны бүртгэл 33, Нөхөн бүртгэл 10, 661 иргэнд иргэний бүртгэлийн лавлагаа олгосон.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 119 иргэнд холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Тайлант сард иргэдээс 13 өргөдөл, санал хүсэлт ирснээс 7 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 4 өргөдлийн хугацаа болоогүй шийдвэрлэгдэх шатанд хүлээгдэж байна.

**Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлж хэрэгжүүлэх зорилгоор 26 үйл ажиллагааг төлөвлөн гүйцэтгэлээ.

Дээрх төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээнд тогтвортой хөгжлийн боловсрол төслийн аргазүйн сургалтад нийт 200 гаруй албан тушаалтныг онлайнаар, 100 алба хаагчдыг танхимын сургалтанд хамрууллаа. Бага ангийн багш нарын туршлага солилцох онлайн сургалт, уулзалтыг ZOOM прогаммаар зохион байгуулахад ерөнхий боловсролын ҮII сургуулийн багш нар "Эцэг эхчүүдийг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулж буй арга туршлага", НТБТ-ийн багш нар "Холимог бүлэгт сургалт зохион байгуулж буй арга, туршлага, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гэрээр сургалт зохион байгуулж буй туршлага", Буянт сумын ЕБ-ийн багш нар "Суралцахуйн бэрхшээл, унших бэрхшээлтэй болон казах сурагчдыг дэмжин сургаж буй арга туршлага", ЕБ-ын III сургуулийн багш нар "Хөгжлийн ялгаатай хүүхдүүдтэй ажиллаж буй кейс туршлага" сэдэвт сургалтуудаар мэдлэг, чадвараа практикт хэрхэн хэрэглэж, хүүхдүүдийг хөгжүүлж буй сайн туршлагыг түгээж ашиглах талаар санал солилцов.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудтай цаг үеийн нөхцөл байдал, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл хэрхэн хангагдсан талаар онлайн уулзалт зохион байгуулж, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөмж чиглэл өглөө. Уулзалтанд 22 сургуулийн 156 удирдлага, багшнар оролцож мэдээлэл солилцов.

НҮБ, Сангийн яам, БСШУСЯ-ы хамтарсан тогтвортой хөгжлийн зорилтууд төслийн санхүүжилтээр зохион байгуулагдсан "Үр дүнд суурилсан төсвийн төсөл" сэдэвт сургалтанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтэн, ОХУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх "Россотрудничество" агентлагтай хамтран Жаргалант сумын ЕБ-ын 7 сургуулийн 14 багш Москвагийн улс түмний найрамдлын их сургууль, Уралын их сургуулийн багш нарын онлайн сургалтанд тус тус хамрагдаж мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Сургалтын чанарыг сайжруулахад мэдээлэл харилцааны технологийг ашиглах төслийн түшиц сургууль болох Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургууль, Үенч сумын ерөнхий боловсролын сургуулиудад дээрх төслийн багаас ирүүлсэн чиглэлийн дагуу онлайн сургалт зохион байгууллаа. Сургалтаар төслийн үйл ажиллагаа, өнөөгийн байдал, багш нарын боловсруулж буй шилдэг 6 видео хичээлийн танилцуулга хийж мэдээлэл харилцааны технологийг ашиглаж буй Япон улсын зарим туршлагаас танилцууллаа.

АНУ-ын Элчин сайдын Яамны санхүүжилтээр хэрэгжих "Аксесс" хөтөлбөрийн 9 дэх ээлжинд 54 хүүхэд бүртгүүлснээс эхний ээлжинд монгол хэлээр зохион бичих шалгалт авч 39 хүүхэд тэнцснээс бичгийн шалгалтад 34 хүүхэд орж 24 сурагч өдрийн ангид 6 сурагч нөөцөд шалгарч 2 жил хичээллэхээр үйл ажиллагаа эхлүүлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын тогтоол шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд боловсролын, соёл, урлагийн талаарх тусгагдсан заалтуудын биелэлт, мөн аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдан хэрэгжүүлж буй “Чадварлаг Ховдчууд”, “Хүүхэд бүр цэцэрлэгт”, “Олон нийтийн оролцоот сургууль-Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрүүдийн 2020 оны эхний хагас жилийн биелэлтийг тус тус тооцон тайлагнаж холбогдох газарт хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд ашиглалтад орох барилга байгууламжийн шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжийн судалгаа, 2019-2020 оны хичээлийн жилд ЕБС-д суралцаж төгссөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа гаргаж БСШУСЯ-д хүргүүлж ажиллав.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, учирч болох гамшгийн аюулын бэлэн байдлыг хангах зэрэг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Khovdtimes, khovdnews.mn, newkhovd.mn сайтууд болон Ховд, Олон ястаны телевизүүдтэй гэрээлэн иргэд, олон нийтэд цахимаар мэдээлэл сургалт сурталчилгаа болон цаг үеийн мэдээллийг хүргэж, 1141 хүн үзэж, 72 хүн хуваалцсан, 8 чиглэлийн шторктой 742 хүн танилцаж 32 хүн хуваалцаж мэдээлэл авсан байна.

Аймгийн онцгой комиссын даргын шийдвэрээр долоо хоногийн 3 дахь өдөр бүр амны хаалтаа зүүж хэвших сурталчилгааг сонгуульд оролцож байгаа нам эвслийн штаб, томоохон супер маркетууд, худалдааны төвүүд зэрэг олон нийтийн газруудаар зохион байгуулж, сурталчилгааны материал, зурагт хуудас 342 ширхэгийг тус тус тарааж ажиллалаа.

Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, БОЭТ-өөс авч нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн төвд хүргүүлэн ажилласан ба 5 дугаар сарын 31-ний байдлаар давхардсан тоогоор насны багц үзлэгт 4347 хүн хамрагдсан.

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж буй “Коронавируст халдвар (COVID - 19)-ын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэл зүйн менежмент” сэдэвт сургалтыг Зэрэг сум, сургагч багш бэлтгэх сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, холбогдох байгууллагуудын 20 мэргэжилтэнүүдийг хамруулж, 20 сургагч багшийг бэлтгэж чадавхижуулснаас гадна Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын газрын оролцоотойгоор мэргэжлийн багийг чадавхижуулах сургалтанд Эрүүл мэндийн газрын 8 мэргэжилтэн, аймгийн мэргэжлийн хяналтын газрын 9 байцаагч, Онцгой байдлын газрын байцаагч, албан хаагч нийт 25 хүнийг хамруулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд коронавируст халдварын цар тахлын үеийн хяналт үнэлгээг хийлээ.

Халдварт өвчний тархвар зүй тандалт судалгааны хүрээнд халдварт өвчний тандалтын мэдээг хам шинжээр 7 хоног болгон авч, EWAR программ дээр шивж, ХӨСҮТөвийн тандалтын албанд хүргүүлж тандалтын мэдээгээр 6 сард цэврүүт халууралт тууралттай хам шинж 2, халууралт тууралттай хам шинж 7, нийт халдварт

өвчний 9 тохиолдол мэдээлэгдсэн ба коронавируст халдварын гэрийн ажиглалтаар 7 хүнийг хяналтанд авч ажиглалтад авсан иргэдийн мэдээллийг холбогдох веб хуудсанд шивж, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлэн байнгын мэргэжлийн зөвлөгөө заавар өгч ажиллалаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан журам, зааврын дагуу цочмог сул саажилтын тандалт судалгааг явуулж Жаргалант сумын 1-5 хүртэлх насны эрүүл хүүхдийн өтгөний 40 сорьцыг авч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Халдварт саагийн лавлагаа лабораторид 37 сорьцыг хүргүүлэн ажиллав.

Тайлант сард Мо-Эн-Ко ХХК-ний Үенч суманд байрлах кемпийн их эмчээс хил гарсан жолооч гүйлгэж, халуурсан тухай мэдээллийн дагуу шуурхай хариу арга хэмжээний нэгдүгээр баг ажиллаж хамрын арчдас, хөөмийн арчдас, өтгөн, шулуун гэдэсний арчдас авч Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вируслогийн лабораторид шинжилгээг 2 төрлийн оношлуурт зэрэг тавьж шинжлэн хариу сөрөг гарсан.

Сонгуулийн санал авах хэсгийн хорооны 91 байрыг зайнаас халуун хэмжигчээр хангаж, дутагдалтай байгаа 34 ширхэг халуун хэмжигчийг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр шийдвэрлэж, аймгийн Онцгой комиссын 22 дугаар тогтоолын дагуу эмч, мэргэжилтнүүдийг хэсгүүдэд ажиллуулж, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Вакцин бүх нийтийн төлөө” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, дархлаажуулалтын дэлхийн 7 хоног, дархлаажуулалтын ээлжит 10 хоногийн өдрүүдийн хүрээнд Ховд, Олон ястан телевиз, Khovd news, khovd times, New khovd зэрэг сайтууд болон Эрүүл мэндийн газрын facebook хуудас, 23 сум, өрхийн ЭМТ, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахим хуудсуудаар дамжуулан бичлэг, фото мэдээ, шторк, сурталчилгааны хуудас, мэдээлэл, зөвлөгөөг ард иргэдэд цахим сайтаар сурталчлан ажиллаж, заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 22 хүүхдийг нөхөн дархлаажуулж, тарваган тахлын вакцинаар эрсдэлт хүн амыг дархлаажуулах ажлыг 2020 оны 6 дугаар сарын 15-аас эхлүүлж, нийт 5000 хүн тун вакциныг Зооноз өвчин судлалын судалгааг үндэслэн холбогдох эрүүл мэндийн төвүүдэд хуваарилаад байна.

“Тэмбүүг устгая” үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн эрт илрүүлэг, үзлэгийн 14 хоногийн мэдээг сард 2 удаа авч нэгтгэн Халдварт өвчин судлалын тандалт судалгааны албанд хүргүүлэн эхний 6 сарын байдлаар ХДХВ-ийн шинжилгээнд 12994, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 12847 хүнийг хамруулж он гарснаас хойш нийт 116 тэмбүүгийн халдвартай хүн оношлогдож тэмбүүгийн эмчилгээний 3 тунт эмчилгээнд хамрууллаа.

Жирэмсний хяналтыг сайжруулах, төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тэмбүү өвчний талаарх мэдлэг чадварыг дээшлүүлж, жирэмсний хяналтыг сайжруулах, тэмбүү өвчний эрт



илрүүлэг үзлэгийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн сум, өрхийн 66 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд танхимаар болон цахимаар холбогдон “Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлье” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хэрэгжилтийн тоон тайланг харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас долоо хоног бүрийн 5 дахь өдөр авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлж тайлант сард шинжилгээнд 766 хүн хамрагдаж, С вирусийн шинжилгээ эерэг гарсан 20, В вирусийн шинжилгээгээр эерэг гарсан 36 иргэнийг хяналтанд авч эмчилгээнд хамруулж байна.

Азийн хөгжлийн банк болон Глобаль сангийн санхүүжилттэй хэрэгжиж буй "Вируст гепатит, Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах" техник туслалцааны төслийн хүрээнд үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тушаал шийдвэрийн эмхэтгэл 50 ширхэг, сүрьеэ судлал 80 ширхэг, гудамжид нус цэрээ хаяхаас урьдчилан сэргийлэх зурагт хуудас 100 ширхэгийг төр, хувийн хэвшлийн 45 эрүүл мэндийн байгууллагуудад, Вируст гепатитийн тандалтын удирдамж 4, С Вируст гепатитын халдварын 600, эхээс хүүхдэд В вируст халдвар дамжихаас сэргийлье 300, Дельта вируст гепатитын халдвар 600, А-Е вируст гепатитын халдварын 600, А вируст гепатитын халдвараас сэргийлье нугалбар 23, Гепатит нь элэгний үрэвсэл нугалбар 23 ширхэг, та вируст гепатитын халдварын эрсдэлтэй юу асуумж 70 ширхэгийг хуваарилан тарааж сурталчлах арга хэмжээ авлаа.

Эх хүүхдийн эрүүл мэндийн талаар Эрүүл мэндийн сайдын 207 дугаар тушаалын дагуу Булган суманд бүртгэгдсэн эхийн эндэгдлийг холбогдох бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэн, шалтгааныг тодорхойлох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцэж дүгнэлт гарган холбогдох материалуудыг яамны Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл, Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн тандалт судалгааны албанд хүргүүллээ.

Тайлант сард эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй Засгийн газрын тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн зарлигийн хагас жилийн биелэлтийг тооцож холбогдох хэлтсүүдэд хугацаанд нь хүргүүлснээс гадна Эрүүл мэндийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргын 2020 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг 64.5 хувийн гүйцэтгэлтэйгээр тооцож хүргүүллээ.

“Эхийн эндэгдлийн өнөөгийн байдал тулгамдсан асуудал” сэдэвт цахим хурлаас гарсан шийдвэрийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж биелэлтийг нэгтгэн ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газарт хүргүүлэн ажиллалаа.

Оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд эрүүл мэндийн үзлэгт 173993 хүнийг хамруулж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 37184 буюу нийт үзлэгээс 21,3 хувийг эзэлж байна. Нийт төрөлт 913 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 11 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Нялхсын эндэгдэл 13 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 14,2 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 5.2 промилээр, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 15 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 16,4 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 6,2 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчин 297 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 51 тохиолдлоор буурсан бөгөөд нийт халдварт өвчний 67,3 хувийг бэлгийн замаар дамжих өвчин, 10,1 хувийн сүрьеэ, 5,3 хувийг салхин цэцэг өвчин тус тус эзэллээ.

Осол гэмтлийн тохиолдол 5 дугаар сарын байдлаар 341 бүртгэгдэж, осол гэмтлийн нас баралт 15 бүртгэгдснээс зам тээврийн ослоор нас баралт 8, бусад осол 7 байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,5 дахь заалтын дагуу харьяа байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт 62060,9 мянган төгрөг, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу 53165,9 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг эрүүл мэндийн салбараар тооцож гаргахад төсөвт байгууллагууд орон нутаг, улсын төсвийн санхүүжилтээ бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээ 70 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд 2020 оны 06 сарын 22-ны байдлаар ажил хайгч иргэд 1871, үүнээс 946 эмэгтэйчүүд байна. Тайлант сард нийт 31 иргэнийг шинээр бүртгэж, идэвхгүй жагсаалтанд байсан 256 иргэний мэдээллийг шинэчиллээ. Шинээр бий болсон 503 ажлын байрыг бүртгэж, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 753 ажлын байрны захиалга авч, байнгын ажлын байранд 195, улирлын ажлын байранд 179, түр ажлын байранд 292 иргэн нийт 666 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд 320 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн, үүнээс ганцаарчилсан зөвлөгөөнд 280, бүлгийн зөвлөгөөнд 40 иргэн хамрагдлаа. Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг 23 иргэнд утсаар өгч, сул чөлөөтэй ажлын байрны зар танилцуулан, ажил хайгч иргэдийн мэдээллийг шинэчлэн бүртгэлээ.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн төсөл нь батлагдсан 30 иргэнтэй гэрээ хийж 73.0 сая төгрөг олгож, ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлийн арга хэмжээнд 4 иргэн төсөл ирүүлж зээлийн өмнөх сургалтанд хамрагдаж банкинд судлагдаж байгаа бөгөөд нийтийг хамарсан ажлын хүрээнд 11 төслийн 298 иргэнийг түр ажлын байраар ханган 61,6 сая төгрөгийн цалин, зохион байгуулалттай ажлын байрны хүрээнд 8 сумын төслийн гүйцэтгэлээр 64 иргэнийг түр ажлын байраар ханган 11,2 сая төгрөгийн урамшуулал олголоо.

Үйлдвэрлэл дээрх сургалтыг “Баясгалант өндөр хөхий ХХК”-тай хамтран зохион байгуулж талх нарийн боовчин мэргэжлээр 20 иргэнийг сургаж сургалтын 70 хувийн урьдчилгаанд 6,7 сая төгрөг зарцуулаад байна.

Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамжийн санд 93.000.000 төгрөг, Улсын төсвөөс ахмад дайчин алдар цолтон ахмадад 55.000.000 төгрөг, алдарт эхийн одонд

1.243.100.000 төгрөг, ахмад настны насны хишигт 550.000.000 төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 217.000.000 төгрөг, халамжийн тэтгэвэрт 2.053.996.950 төгрөг, өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрт 170.080.000 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 849.400.000 төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 397.974.000 төгрөг, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжид 436.392.000, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжид 186.376.000 төгрөг, жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжид 40.000.000 төгрөг, хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид 887.420.000 төгрөг, нийт 7.213.926.450 төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд аймгийн хэмжээнд 2020 оны 06 дугаар сарын 26-ны байдлаар 34521 хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж 3.486.000.000 төгрөгийг олгож шинээр төрсөн 1397 хүүхдийг бүртгэж авсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд тайлант сард аймгийн хэмжээнд 1608 өрхийн 4854 том хүн, 4227 хүүхэд нийт 9081 иргэн хамрагдаж 222,960,000 төгрөгийн санхүүжилтийг зарцууллаа. Халамжийн сангаас ортопедийн тусгай хэрэгсэл авах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авсан эсэхийг программд шалгаж, 14 иргэний бичиг баримтыг хүлээн авч 31 ширхэг ортопедийн туслах хэрэгсэл олгож, waic программд бүртгэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тайлант сард 3 удаа хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 28 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа. Сэтгэл зүйн зөвлөгөөнд насанд хүрэгч 49, хүүхэд 18, цахимаар 5 нийт 72 үйлчлүүлэгч хамрагдсан ба 7 үйлчлүүлэгч давтан зөвлөгөөнд хамрагдсан. Хамрагдсан иргэдийг шалтгаанаар нь авч үзвэл гэр бүлийн харилцааны зөрчлийн асуудлаар – 6, бэлгийн хүчирхийллийн хохирогч – 1, сэтгэл гутрал стрессийн асуудлаар – 5, мэргэжил сонголт, хүүхдийн хүмүүжлийн асуудлаар - 4 үйлчлүүлэгч хамрагдаж, хамрагдсан иргэдийн сэтгэл зүйн байдал тогтворжин учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэхээс гадна тулгамдсан асуудлаа даван туулж чадлаа.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн 2.1, Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн 1.2 дахь заалтыг үндэслэн шинээр гэр бүл болж буй хосуудад гэрлэлтийн баталгааг ёслол төгөлдөр гардуулдаг уламжлалыг бий болгож, хүүхдийн амьдрах анхдагч орчин болох гэр бүлийн тогтвортой байдал, эцэг, эхчүүдэд хамтын амьдралын утга учир, хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, мэдлэг ойлголтыг олгох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах гэрлэх ёслолын танхимыг тохижууллаа.

Зуны улирал эхэлж хүүхдүүд голын ус, бусад зүйлд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж эцэг эхчүүд асран хамгаалагч нарт хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолыг үндэслэн 17 сум болон аймгийн төвийн албан байгууллагуудын эцэг эхийн зөвлөл 55 албан байгууллагуудад гэр бүл дэх хүүхдийн аюулгүй байдал, олон нийтийн үйлчилгээ, тоглоомын талбайн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 33, амаар 18 гомдол нийт 51 дуудлага мэдээлэл ирсэн. Нийт кейс-д нөхцөл байдлын үнэлгээ хийж хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Сумдын хамтарсан баг, холбогдох байгууллагуудад 18 кейс холбон зуучиллаа. Нийт гомдол мэдээллийг хэлбэрээр авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 18, Бэлгийн хүчирхийлэл 3, Гэмт хэрэгт холбогдсон 2, бие мах бодийн 4, сэтгэл санааны 4, эдийн засгийн 2, үл хайхрах хүчирхийлэл 7, эцэг эхийн хариуцлагаа биелүүлээгүй 3 эзэлж байна. Орчноор авч үзвэл олон нийтийн орчинд 2, боловсролын орчинд 1, гэр бүлийн орчинд 28 байна.

Нөхцөл байдлын үнэлгээг 7 гэр бүлд, зөвлөн туслах үйлчилгээг 5 гэр бүлд хийж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй 0-18 насны хүүхдийн судалгааг Цагдаагийн газар, Шүүхээс авч нэгтгэн хүүхдийн мэдээллийн санд төвлөрүүлэн ажиллаж байна.

ШШГГ-ын 457 дугаар нээлттэй хаалттай хорих ангид хүмүүжиж байгаа 15-34 насны хүмүүжигч болон албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд COVID-19 вирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, амьдрах ухаан сургалтыг 12 модуль номноос цахим хэлбэрээр бэлтгэн шат дараатай хүргэж байна.

“Залуучууд Коронавирусын эсрэг нэгдэж байна” залуучуудын аяныг үргэлжлүүлж Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх клубын хүүхдүүдтэй хамтран гол, парк зэрэг хүүхдүүд олноор цуглаж байгаа орчинд очиж амны хаалтны зөв зохистой хэрэглээ, нэг удаа гар ариутгах үйл ажиллагаа үзүүлж сэрэмжлүүлэг хүргэж халдвараас урьчилан сэргийлэх зорилготой брошур тарааж, энэ үйл ажиллагааны хүрээнд давхардсан тоогоор 2000 гаруй иргэдэд зөвлөмж хүргэж, 1200 гаруй брошур тарааж ажиллав.

COVID-19 цар тахлаас сэргийлэх зорилготой улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан ном унших сонирхолтой залуучуудад цахимаар сонирхсон номыг өгч цаг хугацааг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн Залуучуудын хөгжлийн төвөөс 200 гаруй цахим номын сан ажиллуулахаар ажиллаж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг “Ковид-19” цар тахлын үед хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлье” уриан дор нөлөөллийн арга хэмжээг аймгийн Цагдаагийн газрын мэргэжилтэн, хүүхэд хамгаалагч нартай хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор эрчимжүүлэх, бүх түвшинд хүүхдийг аливаа осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг мөрдүүлэх зорилгоор “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээ”-г Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж, Жаргалант сумын 12 багийн нутаг дэвсгэрт хүүхдийг гадна орчны осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар илэрсэн хүүхдэд эрсдэл учруулж болохуйц

зөрчлүүдийг арилгах тухай чиглэлийг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.

**Тав: Сумдын мэдээлэл:**

**Мөнххайрхан сум:** Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 4 хэсэг байгуулж, сумын сонгуулийн хорооноос сонгууль зохион байгуулах мэдээлэл технологийн баг, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудын баг, хэсгийн хорооны дарга гишүүдийг сургаж, томилгоожуулан ажлын чиглэл өгч, 3 мандаттай, 17 нэр дэвшигчид саналаа өгч, зарлагдсан хэсгүүдэд сонгогчийн ирц 86 хувьтай оролцож, маргаан зөрчилгүй санал хураалтыг зохион байгууллаа.

Төрийн байгууллагууд дотоод ажил, байгууллагын тохижилт, үйлчилгээг сайжруулах бүтээлч ажлуудыг санаачлан зохион байгуулж, Тамгын газарт гадна хаалга солих, Засаг даргын өрөөний буйданг шинэчлэх, үүдний танхимд танилцуулга, бахархлын булан хийж, угтах үйлчилгээний тейкийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн төрийн мэдээллийн хур системээс 12 иргэнд лавлагаа мэдээлэл өгч ажиллав.

Хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн биелэлт хэрэгжилтийн явцын тайланг 2020 оны хагас жилийн байдлаар тооцож аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнуудын амралтыг олгож, төгсөх ангийн багш нар 12 дугаар ангийн элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэж байгаа хүүхдүүдэд гарсан шийдвэрийн дагуу давтлага орж, үйлчилгээний ажилтнууд ажиллах хуваарийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг зөвлөмжийн дагуу хийж, ариутгалын бодисыг нөөцөлж, хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ковид - 19 өвчний үед ажиллах горимын дагуу хяналт тавин ажиллав. Нийгмийн хариуцлагын хүрээнд Сэнхэрийн голын ус цэвэрлэх ажилд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллав.

Сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварыг аймгийн ОНХС-ийн 85,0 сая төрөгийн санхүүжилтээр хийгдэхээр тендер шалгаруулалт зарлагдаж “Калдеро тубо” ХХК гүйцэтгэгчээр шалгарч засварын ажлыг эхлүүлээд байна.

Сумын Эрүүл мэндийн төв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор элэгний В, С вирусын үзлэг шинжилгээнд эхний хагас жилийн байдлаар нийт 174 хүнд шинжилгээ хийж В вирустай-5, С вирустай-3 хүн илрүүлсэн. Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг илрүүлэх шинжилгээнд нийт 317 хүнийг хамрууллаа. Хөхний хавдар илрүүлэх үзлэгт 20-29-насны 119 охидод үзлэг хийж хамралт 67,6%, умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэг, шинжилгээнд 64 эмэгтэйг хамруулж хамралт 55% тай байна. Артерийн даралт ихсэлт, чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 210 хүнийг үзлэгт хамруулсан.

Эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн төвд нийт 199 хүн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд уламжлалт эмчилгээнд 242 хүн хамрагдсан, сэргээн засах тусламж үйлчилгээнд 130 хүн хамрагдлаа.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд эх барихын тусламж үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа багаж тоног төхөөрөмж эм, эмнэлгийн хэрэгслийг шинээр орсон ажилчдад таниулах зорилгоор “Эх барихын тусламж үйлчилгээний чанарын өдөрлөг” зохион байгуулж эмнэлгийн эмч, сувилагч нийт 16 хүнийг хамрууллаа. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор 54 нэр төрлийн эмийн захиалгыг эрүүл мэндийн төвийн дарга, эм зүйч нар хамтран өгсөн.

Короновируст халдвар түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллагууд, ард иргэдэд ариутгалын бодис бкг, 20 ширхэг гар ариутгагч, 25 хайрцаг бээлий, нэг удаагийн өмсгөлийн нөөц бүрдүүлж, халдвараас сэргийлэх зөвлөмж нийт 700 ширхэг тараах материалыг ард иргэдэд хүргүүлж ажиллав.

**Эрдэнэбүрэн сум:** Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, нийт 1583 сонгогч нэрийн жагсаалтанд бүртгэгдсэнээс 1241 сонгогч буюу сонгогчдын 78,4% нь сонгуульд оролцлоо.

Сумын хэмжээнд мал угаалгад нийт 156857 мал хамрагдхаас бод 14930, бог 141261 мал тус тус хамрагдаж 92,7% -тай хамрагдсан.

АТБӨЯТХ-ийн татварт 221 машины 7939.6 мянган төгрөг, агаарын бохирдолд 927.6 мянган төгрөгийг улс, аймгийн төвлөрсөн төсөвт тушаав.

"Хашаандаа сайхан амьдарцгаая" төсөл амжилттай хэрэгжиж эхний 5 айлын 0.07 га газар бүхий хашаа баригдаж ашиглалтанд оруулж, цаашид ундны цэвэр, бохир усанд холбох инженерийн шугамын ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын шинэ барилгыг 1 тэрбум төгрөгийн сахүүжилтээр “Цагаан бөлбөө” ХХК гүйцэтгэж ашиглалтанд хүлээн авлаа.

Төрөөс хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр баримталж буй бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хоршоодын бизнесийн хөгжлийн түвшинд гарч буй ахиц дэвшил, нийтлэг тулгамдаж буй асуудлыг тэдгээрийн удирдлага, гишүүдийн оролцоотойгоор тодорхойлж, цаашид баримтлах бодлого чиглэлийг тодорхойлхоор сумын 13 хоршооны хөгжлийг үнэллээ.

Аймгийн ИТХ-аас санаачлан хэрэгжүүлж буй “Хог биш мод тарья” хөдөлгөөнд нэгдэж сумын төвд 1500 ширхэг мод шинээр тарьж, ОУ-ын "Ойн өдөр"-ийг угтан сумын ойн зурваст ус оруулах, далан сэргээх, Ховд Сафари ХХК-ийн гүйцэтгэлээр 49-ийн талбайд 18га газарт 6000 мод тариалах ажлыг ард иргэдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэн хашааллаа.

Сумын Засаг даргаас санаачлан “Ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян өрнүүлэх тухай” А/37 дугаар захирамж гаргаж, малчид мал бүхий иргэдийн малын хашаа, төл малын пүнз байрыг ариутган халдваргүйтгэж өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа үхсэн малын сэг зэмийг устгалын цэгт булж устгууллаа.

**Жаргалант сум:** Сумын Засаг даргын 2020 оны А/214 дугаар захирамжийн дагуу 2020 оны эхний хагас жилийн мал тооллогыг зохион байгууллаа. Сумын хэмжээнд 5 албан газар, 2 аж ахуйн нэгж 155 иргэн үр тариа 1,1 га-д, тэжээлийн ургамал 10 га-д, төмс 80,8 га-д, хүнсний ногоо 133,7 га талбайд тус тус тариалалт

хийж, “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрөөр 42 аж ахуйн нэгж байгууллагын 1917 ажилтан албан хаагчид 3,5 га газарт нийт 3945 ширхэг мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/158 дугаар захирамжийг хэрэгжүүлж “Бидний хот-Ногоон хөгжил” аян өрнүүлэн хотын төвийн эдэлбэрт газар байгаа нийт 250 ширхэг хайс хашлага, цэцгийн мандлуудыг арчилж хамгаалах, тариалалт хийхээр 67 аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуцуулан гэрээлж эзэнжүүллээ.

Буянт голоос услалтын системээр түгээж байгаа усыг зохистой ашиглах, мод тариалдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжиж үйл ажиллагааг нь зохицуулах, ус ашиглалтын хуваарь гаргах, ус дамжуулах хоолойг цэвэрлэх, хотын төв хэсэгт ус ашиглах ажлыг сумын Засаг даргын 2020 оны А/130 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 10 иргэний хамтаар 21 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

“Буянт голын сав дагуу газарт дагаж мөрдөх журам”-ыг шинэчлэн боловсруулж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн 2020 оны 105 дугаар тогтоол батлуулж, дээрх журмыг иргэдэд сурталчлан мэдээлж, зуслангийн хориотой бүсэд байгаа мал бүхий 6 өрх айлд байцаагчийн хугацаатай мэдэгдэх хуудас өгч зөрчлийг арилгуулаад байна. Журмын дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүжилтээр зуслангийн бүс нутгийн хог хаягдлыг 3 хоногийн давтамжтайгаар зорилтод бүлгийн 10 иргэнээр тогтмол цэвэрлүүлж байхаар Хот тохижилтын газартай гэрээ байгуулан ажиллаж байна.

**Буянт сум:** УИХ, Засгийн газрын тогтоол, сумын ИТХ-н тогтоол, Засаг даргын захирамж болох хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 671 гаруй хууль эрх зүйн актуудаар цахим сан бүрдүүлэн 26 иргэн, 2 аж ахуйн нэгжид хуулийн зөвлөгөө өгч ажиллалаа.

“Татвар төлөгчдийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Татварын байцаагч, Эрхзүйн ажилтан хамтран иргэдэд татварын тухай хууль сурталчлах, төсвийн орлого бүрдүүлэлт түүний ач холбогдол, татвар төлөх сэтгэлгээг хөгжүүлэх, иргэд олон нийтэд татварын ерөнхий хуулийн мэдлэг олгох үүднээс төсөвт байгууллагуудын албан хаагч иргэдийн дунд “Элсэн цаг” тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүн эмнэлэг, Цэцэрлэг, Соёлын төв, Норжинхайрхан багийн гишүүд оролцож Норжинхайрхан баг 1 байр эзэлж, Хүн эмнэлгийн баг 2 байр тус тус эзэллээ.

Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд малын хулгай их гардаг, хулгайд ихээр өртдөг Нарийн гол, Цагаанбургас багийн нутгуудаар сумын Хэсгийн төлөөлөгч, цагдаа, багийн Засаг дарга нар хамтран морин эргүүлээр ажиллаж мал мах бэлтгэж худалдан борлуулж байгаа иргэдийн гарал үүслийн бичигтэй эсэхийг шалган, ард иргэдтэй уулзаж яриа таниулга хийж гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн нөхөн төлбөр, гомдлыг барагдуулахаар ажиллаж байна.

**Дөргөн сум:** Монгол Улсын УИХ-ын ээлжилт сонгуульд сумын сонгуулийн хороо, багийн 4 хэсгийн хороо, мэдээллийн технологийн 4 даамал, 38 төрийн албан

хаагч ажиллаж, хуулийн дагуу хариуцлагатайгаар амжилттай зохион байгууллаа. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтийг хангаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, ард иргэдийг маск, бээлий, гар ариутгагчаар хангаж, мэдээлэл өгч ажилласан. Сумын хэмжээнд 1793 сонгогч саналаа өгөх байснаас 1558 сонгогч санал өгч, 86.8%-ийн ирц оролцоотойгоор зохион байгууллаа.

Дэлхийн зөн ОУБ-ын хөрөнгө оруулалтаар зорилтот бүлгийн 15 өрхөд өрх тус бүрт 3, нийт 45 тугалтай үхэр, 3 өрхөд өрх тус бүрт 15, нийт 45 ишигтэй ямаа худалдан авч өрхийг малжууллаа.

ОНХС-ийн 3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аргалант багийн төвийн барилгын дээврийн засвар, Сээр багийн төвийн урсгал засварыг байгууллагын гэрээт ажилчид засварлаж, Аргалант багийн төвийн урсгал засварыг Дөргөн УЦСтанцын 2 сая төгрөгийн санхүүжилтээр засварлаж хүлээн авлаа.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээгээр иргэний үнэмлэхийн лавлагаа 22, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа 7, гэрлэлтийн лавлагаа 4 иргэнд тус тус олголоо.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 121 заалт 77,1%, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн суманд холбогдолтой 50 заалт 78.9 %, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийн 94 ажил 67.8%, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийн суманд холбогдолтой 65 заалт 84.5%, Засгийн газрын тогтоол шийдвэрийн суманд холбогдолтой 64 заалт 87.9%, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн суманд холбогдолтой 37 заалт 77.2%-ийн биелэлттэй хэрэгжилтийг тооцон аймгийн ЗДТГ-т хугацаанд хүргүүлж ажиллав.

Агваш багийн малчид иргэдийн хүсэлтийн дагуу улсын төсвийн 180,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Untel- сүлжээний тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж эхлээд байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тайлант сард нийтдээ 379 тэтгэвэр авагчдад 134865.9 мянган төгрөгийн тэтгэвэрийг олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 287, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 29, тахир дутуугийн тэтгэвэр авагч 63 иргэнд тус тус олгож шинээр 1 иргэнд малчны тэтгэвэр тогтоов.

Сайн дурын даатгалд нийт 204 даатгуулагчийн 14282.1 мянган төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 60061.3 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлж шинээр 1 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгууллаа. Эрүүл мэндийн даатгалд 31 даатгуулагчийн 1399.8 мянган төгрөгийн орлого оруулсан.

Чоно харайх голын усны түвшин ихсэж байгаатай холбогдуулан Дөргөн УЦСтанц, сумын ЗДТГ, Байгаль орчны байцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, санал дүгнэлтийг БОАЖЯ-нд уламжилсан. Мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг ажиллаж байна.



Нуурын орчныг гадны бохирдлоос хамгаалах зорилгоор сумын ОНХС-ийн 5,0 сая төгрөгийн хөрөнгөөр 3,0 км газарт хамгаалалтын тор татаж засварлах ажлыг Өгөөмөр багийн иргэн М.Даваажав хийж гүйцэтгэн дуусгаж ажлыг хүлээн авлаа.

Сумын Мал эмнэлгийн үржлийн тасаг нэгдсэн системийн хүрээнд 1500 кг малын мах, 26 толгой амьд малд гарал үүслийн бичгийг цахимаар олгож, хаврын төлөвлөгөөт 7 төрлийн вакцинжуулалтанд 410558 малыг хамрууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв амбулатороор 235 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, нийт 45 удаа дуудлаганд явж, 48 иргэнийг хэвтүүлэн эмчилж, шинээр 6 эхийг хяналтанд авч, эсэн мэнд төрүүллээ.

Урьдчилан сэргийлэх шинжилгээ, оношлогоогоор 38 иргэнийг ДОХ тэмбүүгийн, 17 иргэнийг элэгний В,С вирусийн, 8 иргэнийг сахарын, 18 иргэнийг хеликобактерийн шинжилгээнд хамруулж, 9 иргэнд ЭХО үзлэг, 11 иргэнд зүрхний цахилгаан бичлэг хийж, Хеликобактери илэрсэн 13 хүнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, эмчилж байна.

“Тэмбүүг устгая” аяны хүрээнд аймгийн ЭМГ-аас зохион байгуулсан цахим сургалтанд сумын ЭМТ-ийн эрхлэгч эмч, лаборант, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, дүн бүртгэгч нар хамрагдаж, зорилтот бүлгийн 346 иргэнийг шинжилгээнд хамруулж өвчний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.